

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫГ ЦАХИМААР ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРМЫН ТӨСӨЛ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас /Цашид “цахим хурал” гэх/ зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Цахим хурал гэдэг нь хувьцаа эзэмшигчдийг бүртгэх, хурлын зар болон хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалыг хүргэх, хурлын үйл ажиллагааг шууд дамжуулах, санал асуулгыг урьдчилсан байдлаар хүлээн авах, хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулах, тооллогын дүн болон хурлаас гарсан шийдвэрийг шуурхай, ил тод хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, Хороонд дамжуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хадгалах зэрэг үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулахыг хэлнэ.

1.3.Хувьцаат компани нь энэхүү журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:

1.3.1.цахим /бүрэн зайнаас зохион байгуулах/;

1.3.2.хосолсон /танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулах/.

1.4.Хувьцаат компани нь цахим хурлаа хувьцаа эзэмшигчид хэрэглэхэд энгийн, нэвтрэхэд хялбар, хүртээмжтэй, ил тод, найдвартай, мэдээллийн аюулгүй байдлыг ханган зохион байгуулах, эсхүл мэдээллийн технологийн компанийн програм хангамжийг гэрээний үндсэн дээр ашиглан зохион байгуулж болно.

1.5.Энэхүү журмын 1.4-т заасан мэдээллийн технологийн компани нь цахим хурлын програм хангамжийн үзүүлэлт, нөхцөлүүд бүхий танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, урьдчилан бүртгүүлсэн байна. Хороо бүртгэлтэй этгээдийн жагсаалтыг өөрийн цахим хуудсанд байршуулна.

1.6.Цахим хурал нь дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

1.6.1.хурлын зар, дэг, хэлэлцэх асуудалтай холбоотойгоор урьдчилж бэлдсэн, болон хурлын явцад тавигдсан материалтай танилцах;

1.6.2.цахимаар бүртгүүлэх, саналаа өгөх, асуулга тавих, цахим саналын хуудсаар саналаа өгөх;

1.6.3.хурал болохоос өмнө тооллогын комисст саналаа цахимаар урьдчилан хүргүүлэх;

1.6.4.хурлын үйл ажиллагааг онлайнаар шууд үзэж танилцах;

1.6.5.хурлын шийдвэр, саналын хураалтын тооллогын дүнгийн мэдээлэлтэй шуурхай танилцах.

1.7.Хаалттай компанийн хувьд энэхүү журмыг баримтлах нь нээлттэй болно.

## ХОЁР. ЦАХИМ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАХ

2.1.Хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит цахим хурлыг Компанийн тухай хуулийн 59.4-т заасан хугацаанд, ээлжит бус цахим хурлыг мөн хуульд заасан эрх бүхий этгээд хэдийд ч зарлан хуралдуулж болно.

2.2.Хувьцаат компани нь цахим хурлын мэдэгдлийг холбогдох шийдвэр, баримт бичгийн хамт Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх, мөн хурлаар хэлэлцэх асуудлын материалыг танилцуулах, саналын хуудасны бүрдүүлбэр, санал авах ажиллагааны

талаар тавигдах шаардлагын талаар мэдээлэх, тооллогын комисс байгуулах, хурлын зар хүргэх, олон нийгэд мэдээлэх зэрэг үүргээ Компанийн тухай хууль, “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д зааснаар хувьцаа эзэмшигчдийг хуралд биечлэн оролцуулах буюу уламжлалт хэлбэрээр хуралдуулахтай нэгэн адил хэрэгжүүлнэ.

2.3.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь компанийн дүрэм, үйл ажиллагааны журамд хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахимаар зохион байгуулахад шаардлагатай нэмэлт зохицуулалтыг оруулна. Компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахаар дараах тохиолдолд шийдвэрлэхээр тусгаж болно. Үүнд:

2.3.1.ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчид санал, шаардлага гаргасан;

2.3.2.ТУЗ шийдвэр гаргасан.

2.4.ТУЗ нь энэ журмын 2.3.1-д заасан санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг цахимаар хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргана. Цахим хурал хуралдуулах шийдвэр гарсан тохиолдолд санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна.

2.5.Хувьцаат компани нь цахим хуралд ашиглагдах програм хангамж, түүнийг хэрхэн ашиглах, мэдээллийн нууцлалыг хэрхэн хангах талаар дэлгэрэнгүй заавар, зөвлөгөө бүхий мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд цахимаар хүргэнэ.

## ГУРАВ. ЦАХИМ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

3.1.Цахим хурлыг тухайн хувьцаат компани өөрөө, эсхүл гэрээний үндсэн дээр энэ журмын 1.5-д заасан бүртгэлтэй этгээдийн програм хангамжийг ашиглан зохион байгуулж болно.

3.2.Цахим хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг биеийн байцаалттай /иргэний үнэмлэх, гадаад паспорт/ нь тулган баталгаажуулалт хийж, бүртгэнэ. Компани нь хувьцаа эзэмшигчийг танин баталгаажуулах, мэдээлэл илгээх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор баталгаат цахим шуудан, гар утасны дугаар зэрэг мэдээллийг нэмж бүртгэнэ.

3.3.Хувьцаат компани нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан нэвтрэх эрх, нууц үг бүхий мэдээллийг цахим хуралд оролцохоор бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдэд илгээнэ. Уг нэвтрэх эрх, нууц үгийг ашиглан хувьцаа эзэмшигч нь цахим хуралд оролцох, саналаа өгөх боломжтой байна.

3.4.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас цахим хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэлийн өдрөөр нь гаргаж, цаасан болон цахим хэлбэрээр цахим хурал зохион байгуулагчид хүргүүлнэ. Бүртгэлийн өдрөөр хувьцаат компанийн хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, эсхүл номинал эзэмшигч тухайн цахим хуралд оролцох эрхтэй. Хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд холбогдох баримтаар нотолгоог хангах үүрэгтэй.

3.5.ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдийн бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт оруулж болно.

3.6.Цахим хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд шуурхай зөвлөгөө, туслалцаа үзүүлэх мэдээлэл харилцааны цахим суваг болон хүлээн авах дугаар ажиллуулна.

3.7.Хувьцаат компани нь хуралд ашиглагдах техник, технологийн хэвийн, тасралтгүй ажиллагааг урьдчилан шалгасан байна.

3.8.Хувьцаат компани нь бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчийг цахим хурал эхлэхээс нэг цагийн өмнө програм хангамжид нэвтрэх боломжоор хангана.

3.9.Хувьцаа эзэмшигч цахим хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгагдсан асуудалтай холбоотой асуулт, саналаа тухайн хурал болох өдрөөс өмнө урьдчилан өгөх болон хурлын үеэр хэлэлцүүлэгт оролцох, асуулт тавих боломжийг бүрдүүлнэ.

#### ДӨРӨВ. ЦАХИМ САНАЛ ХУРААЛТ

4.1.Цахимаар өгсөн санал нь хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцсонтой адил хүчин төгөлдөр байна.

4.2.Цахим хурлын санал хураах програм хангамж нь саналын хуудас бүрэн гүйцэд, зөв бөглөгдсөн эсэхэд хариу үйлдэл үзүүлж, анхааруулга өгөх боломжтой буюу саналын хуудас хүчингүй болох эрсдэлийг хаасан байна.

4.3.Цахим хуралд бүртгүүлэн оролцож байгаа хувьцаа эзэмшигч нь хурлаар хэлэлцсэн асуудал бүрээр өөрийн саналаа өгч, баталгаажуулна. Хувьцаа эзэмшигч өөрийн баталгаажуулсан саналаа нягталж харах боломжтой байна.

4.4.Санал хураалтын тооллогын дүнг тооллогын комисс тогтоолоороо шууд баталгаажуулна.

#### ТАВ. МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ

5.1.Хувьцаат компанийн, эсхүл мэдээллийн технологийн компанийн цахим хурлын програм хангамж нь Хорооны мэдээллийн сантай шууд холбогдсон байна.

5.2.Цахим хурал хуралдаж дууссаны дараа тухайн хуралтай холбоотой дараах мэдээллийг Хорооны мэдээллийн санд нэн даруй дамжуулна. Үүнд:

5.2.1.цахим хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт, тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээлэл;

5.2.2.цахим хурлын ирцийн үр дүн;

5.2.3.цахим хурлаар хэлэлцсэн асуудал бүрийн санал хураалтын үр дүн;

5.2.4.цахим санал хураалтад оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас.

5.3.Цахим хурлын материал, санал хураалтын баримтыг засварлах, өөрчлөх боломжгүй хэлбэрээр архивын баримт болгон цахим хэлбэрээр Хорооны болон хувьцаат компанийн мэдээллийн санд хадгалагдана.

#### ЗУРГАА. БУСАД

6.1.Цахим хурлыг хуралдуулах боломжгүй техникийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг ТУЗ товлоно.

6.2.Энэ журмын 6.1-д давагдашгүй хүчин зүйлсээс болсон нөхцөл байдал мөн хамаарна.

6.3.Хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Улсын байцаагч тухайн хувьцаа эзэмшигчдийн цахим хурлын үйл ажиллагаанд оролцож, хяналт тавина.

6.4.Хувьцаат компани нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хараат бус хөндлөнгийн ажиглагчийг цахим хурлын үйл ажиллагаанд оролцуулж болно.